



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР  
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,  
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

## БҮХ ШАТНЫ СУРГУУЛИУДАД ТӨРИЙН ДАЛБААГ ХЭРЭГЛЭЖ БУЙ БУСАД УЛСЫН ТУРШЛАГА

Судалгааны төрөл:	Мэдээлэл лавлагаа
Судалгааны код:	СТ-26/403
Хугацаа:	2026.01.14
ЗАХИАЛАГЧ:	УИХ-ын гишүүн Ж.Золжаргал
Хянасан:	ПСХХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Г.Гэсэр ПСХХ-ийн Судалгааны хэлтсийн дарга Э.Дашзэгвэ
Судалгаа удирдсан:	Судалгааны хэлтсийн зөвлөх Б.Оюун-Эрдэнэ
Судлаач:	Б.Оюунчимэг

Улаанбаатар хот  
2026

## Агуулга

<i>Хүснэгтийн жагсаалт</i> .....	3
<i>Удиртгал</i> .....	4
<i>НЭГ. МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ДАЛБААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР</i> .....	5
<i>ХОЁР. ТӨРИЙН ДАЛБААГ СУРГУУЛЬД ХЭРЭГЛЭЖ БУЙ БУСАД УЛСЫН ТУРШЛАГА, ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ</i> .....	6
2.1. Улс орнууд Төрийн далбааг сургуульд хэрэглэх эрх зүйн орчны зохицуулалт .....	6
2.2. Төрийн далбааг сургуулийн орчинд хэрэглэх давтамж, хугацаа.....	11
<i>ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН</i> .....	15
<i>НОМ ЗҮЙ</i> .....	16



## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төрийн далбааг бүх шатны сургуульд сургалтын байгууллагад хэрэглэх зохицуулалттай улс орнуудын эрх зүйн зохицуулалт .....	6
--	---

## УДИРТГАЛ

“Бүх шатны сургуулиудад төрийн далбааг хэрэглэж буй бусад улсын туршлага” сэдэвт судалгааг Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

**Судалгааны зорилго:** Бүх шатны сургуулиудад төрийн далбааг хэрэглэж буй улс орнуудын эрх зүйн орчныг судлах.

**Судалгааны хамрах хүрээ:** Судалгаанд Америкийн Нэгдсэн Улс (цаашид АНУ гэх), Австралийн Холбооны Улс (цаашид Австрали гэх), Европын орнуудаас Бүгд Найрамдах Франц Улс (цаашид Франц гэх), Бүгд Найрамдах Итали Улс (цаашид Итали гэх), Оросын Холбооны Улс (цаашид ОХУ гэх), Азийн орнуудаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс (цаашид БНХАУ гэх), Бүгд Найрамдах Энэтхэг Улс (цаашид Энэтхэг гэх), Бүгд Найрамдах Филиппин Улс (цаашид Филиппин гэх), Бүгд Найрамдах Сингапур Улс (цаашид Сингапур гэх), Тайландын Хаант Улс (цаашид Тайланд гэх) улсуудын бүх шатны сургуульд төрийн далбааг хэрэглэж буй эрх зүйн орчны зохицуулалтыг судална.

**Судалгааны ажлын бүтэц:** Судалгааны тайлан нь дараах үндсэн гурван хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Монгол Улсад Төрийн далбааг бүх шатны сургуульд ашиглах эрх зүйн орчин
2. Бусад улс оронд төрийн далбааг ашиглаж буй зохицуулалтууд
3. Төрийн далбааг хэрэглэж буй туршлага

**Судалгааны арга зүй:** Судалгааг тухайн улсын холбогдох хууль тогтоомж болон олон улсын байгууллагуудаас эмхлэн нийтэлсэн судалгаа, зөвлөмж, болон бусад мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачдын бүтээлд судалгааны удирдамжид заасан чиглэлийн дагуу холбогдох мэдээллийг харьцуулан судлах, нэгтгэн дүгнэх арга зүйг ашиглан гүйцэтгэв.

Түлхүүр үг: *Төрийн далбаа, Төрийн бэлгэ тэмдэг*

Key words: *National flag, National symbol*

## НЭГ. МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ДАЛБААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР

Төрийн далбаа нь тухайн улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдлийг илэрхийлэх төрийн үндсэн бэлгэдлийн нэг юм.

Монгол Улсын Төрийн далбааны эрх зүйн байдал нь Үндсэн хууль<sup>1</sup> болон Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулиар<sup>2</sup> зохицуулагддаг. Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь Төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал мөн” (§12.1), “Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ” (§12.2) гэж тус тус заасан.

### Төрийн далбааг мандуулах, байрлуулах газар

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн дөрөвдүгээр бүлэгт Монгол Улсын Төрийн далбаа, түүнийг үйлдэх, дүрслэх, мандуулах, байрлуулах, дурсгах зохицуулалтыг тусгасан байдаг. Тус хуулийн 13 дугаар зүйлд Төрийн далбааг байнга, түр болон бусад тохиолдолд мандуулах газрыг тодорхойлсон байдаг.

### Төрийн далбааг хэрэглэх эрх чөлөө

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд зааснаар, Иргэд, өрх, аж ахуйн нэгж, байгууллага нь төрийн бэлгэ тэмдгээ гүнээ дээдлэн хүндэтгэж, бүх ард түмний баяр наадам, ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ болон бусад үед Төрийн сүлд, далбаагаа барих байрлуулах, мандуулах буюу Төрийн дууллыг эгшиглүүлэх эрх чөлөөг олгосон байна.

### Төрийн далбааг дээдлэн хүндэтгэх санаачилгыг түгээн дэлгэрүүлэх

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2011 оны 136 дугаар зарлиг “Монгол хүний үндэсний бахархал, эх оронч үзлийг хөхиүлэн дэмжих зорилгоор монгол түмний их түүх, эв нэгдэл, цог хийморийн илэрхийлэл болсон Төрийн далбаагаа өргөө гэр, албан тасалгаандаа ёс төртэй залж, гүн хүндэтгэлтэй хэрэглэж хэвшихийг Монгол Улсын нийт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад уриалсугай”.

Харин Төрийн ёслол, хүндэтгэлийн үед Төрийн бэлгэ тэмдгийг хэрэглэх журмыг Ерөнхийлөгчийн 2015 оны 119 дүгээр зарлигаар баталсан байдаг.

### Төрийн далбааг бүх шатны сургуульд хэрэглэж болох эрх зүйн орчин

Харин Боловсролын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлээр боловсролын хөтөлбөр, агуулга стандартыг зохицуулсан байдаг бөгөөд 14.4.1-т бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт “монголын түүх, монгол хэл, уран зохиол, үндэсний бичиг, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, **эх оронч сэтгэлгээ, төлөвшил**” гэсэн агуулгыг заавал тусгаж, боловсролын сургалтын байгууллага өмчийн хэлбэр харгалзахгүй хэрэгжүүлнэ хэмээн заасан байна.

Үүнээс үзэхэд Монгол Улсад бүх шатны сургуульд төрийн далбааг гүнээ дээдлэн хүндэтгэн хэрэглэх эрх чөлөө хуулиар олгогдсон боловч Төрийн ёслол, хүндэтгэлийн үеэс бусад тохиолдолд төрийн далбааг хэрхэн хэрэглэх талаар тусгайлсан зохицуулалт байхгүй байна.

---

<sup>1</sup> Монгол Улс. Монгол Улсын Үндсэн хууль (1992 [2023]). Хандах: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

<sup>2</sup> Монгол Улс. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль (1994 [2024]). Хандах: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=496>

## ХОЁР. ТӨРИЙН ДАЛБААГ СУРГУУЛЬД ХЭРЭГЛЭЖ БУЙ БУСАД УЛСЫН ТУРШЛАГА, ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Их Британийн Хатан хааны Белфастын их сургууль (Queen's University Belfast)-аас 2017 онд хийсэн улс орнуудын далбааны утга, бэлгэ тэмдгийн талаар 11 орны жишээн дээр судалсан судалгааны үр дүнд дийлэнх улсад иргэд Төрийн далбаа нь эерэг сэтгэл хөдлөл (бахархал, баяр) болон тэгш эрхийн ойлголтыг холбодог. Ялангуяа эх оронч, үндсэрхэг хандлага өндөр байх тусам хүмүүс төрийн далбаагаа эергээр, тэгш эрх, шударга ёстой илүү их холбож ойлгодог (Queen's University Belfast, 2017). Гэвч энэ ойлголт нь зарим тохиолдолд бусад улсыг үл зөвшөөрөх, давамгайлах үзэлтэй хавсарч болзошгүйг тус судалгааны тайланд онцолсон байна (мөн тэнд).

Улс орнуудын ерөнхий боловсролын сургуулиудад төрийн дуулал эгшиглүүлэх, төрийн далбааг мандуулах, тангараг өргөх ёслол үйлдэх уламжлал түгээмэл байна. Иймд судалгааны энэ хэсэгт АНУ, Европын орнуудаас Франц, Итали, ОХУ, Азийн орнуудаас БНХАУ, Энэтхэг, Филиппин, Сингапур, Тайланд болон Австрали зэрэг улсуудын сургуулийн орчинд төрийн далбааг хэрэглэх эрх зүйн орчны зохицуулалтыг судлав.

### 2.1. Улс орнууд Төрийн далбааг сургуульд хэрэглэх эрх зүйн орчны зохицуулалт

Судалгаанд хамрагдсан улс орнууд ихэвчлэн төрийн бэлгэ тэмдгийн тухай болон бусад адил төстэй хуульдаа Төрийн далбааны төлөв байдал, мандуулах газар, далбааны ёслолын талаарх ерөнхий зохицуулалтыг хийж, харин гол төлөв боловсролын салбар хариуцсан сайдын холбогдох шийдвэр дүрэм журам, эсхүл тухайн боловсролын байгууллагын дотоод журмын хүрээнд төрийн далбааг бүх шатны сургуульд хэрэглэх үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан байна.

Түүнчлэн Төрийн далбааг сургуулийн орчинд хэрэглэх явдал нь хүүхэд, залуучуудын “эх оронч үзэл, үндэсний эв нэгдэл, иргэний ёс суртахуун, үнэт зүйлийг төлөвшүүлэх, бэхжүүлэх” зорилготой хэмээн улс орнууд нийтлэг байдлаар тодорхойлсон байна.

*Хүснэгт 1. Төрийн далбааг бүх шатны сургуульд сургалтын байгууллагад хэрэглэх зохицуулалттай улс орнуудын эрх зүйн зохицуулалт*

Улс орнууд	Холбогдох хууль тогтоомж	Зохицуулалт
АНУ	– Холбооны түвшний далбааны тухай хууль <sup>3</sup>	Далбааны тухай хуулийн нэгдүгээр бүлэгт Төрийн далбааны дүрслэл, агуулга, хэрхэн мандуулах, хүндэтгэх, далбаанд тангараг өргөх удирдамжийг нарийвчлан зохицуулсан байдаг. Тус хууль нь заавал дагаж мөрдөх зохицуулалтыг агуулаагүй бөгөөд шүүхийн практикт эдгээр заалтуудыг тунхаглалын (declaratory) болон зөвлөмжийн (advisory) шинжтэй хэм хэмжээ гэж үздэг байна (Congressional Research Service, 2019). Далбааны эрх зүйн байдлыг тодорхойлсон тус хуулийн §6(g)-д хичээлийн өдрүүдэд сургуулийн байр бүрийн дотор эсвэл ойролцоо далбааг мандуулна гэсэн зохицуулалт тусгагджээ.

<sup>3</sup> АНУ. Title 4 – Flag and Seal, Seat of Government, and The States (1947). Хандах: <https://www.law.cornell.edu/uscode/text/4>

		Харин дийлэнх муж улсууд улсын сургуулийн сурагчдад Тангараг өргөх ёслолыг өдөр бүр үйлдэх боломжийг сургуулиудад олгохыг заасан хуультай байдаг (Congressional Research Service, 2019).
	– Виржиниа мужийн хууль <sup>4</sup>	Виржиниа мужийн хуулийн §22.1-202. “АНУ болон Виржиниа мужийн төрийн далбааны түүх, зарчмын зааварчилгаа, Америкийн төрийн далбаанд үнэнч байхаа тангараглах ёслол, Боловсролын зөвлөлийн удирдамжууд” хэсэгт холбогдох зохицуулалтуудыг тусгасан байдаг. Тухайлбал, §22.1-202(C)-д Сургуулийн зөвлөл бүр сургуулийн анги танхим бүрд өдөр бүр Төрийн далбаанд үнэнч байхаа тангараглах (Pledge of Allegiance) ёслолыг үйлдэхийг шаардах бөгөөд анги танхим бүрд АНУ-ын төрийн далбааг байршуулсан эсэхийг баталгаажуулна. Сургуулийн зөвлөл нь хичээлийн өдрийн аль тохиромжтой цагт тангараг өргөх ёслолыг зохион байгуулах цагийг тогтооно.
Франц	– Боловсролын тухай хуульд <sup>5</sup> 2019 онд оруулсан нэмэлт өөрчлөлт	Боловсролын тухай хуулийн “§L.111-1-1 дүгээр зүйлд ... Францын гурван өнгийн далбаа, Европын далбааг гэрээний дагуу улсын болон хувийн сургууль, дунд боловсролын байгууллагуудын фасад дээр байрлуулна”, “§L.111-1-2 дугаар зүйлд Францын цэнхэр, цагаан, улаан гэсэн гурван өнгийн далбааг гэрээний дагуу улсын болон хувийн бага, дунд сургуулийн анги танхим бүрд байрлуулна гэж тус тус заажээ.
Австрали	– Австралийн Төрийн далбааны тухай хууль <sup>6</sup>	Төрийн далбааны тухай хуулиар далбаануудын статусыг тодорхойлсон байдаг.
	– Австралийн Төрийн далбааг ашиглах журам (Australian Government, 2025)	Харин Төрийн Далбаануудыг мандуулах, байрлуулах, ёслолын үйл ажиллагааг Австралийн Төрийн далбааг ашиглах журмаар зохицуулсан байна. Тус журамд сургууль болон албан байгууллагууд далбаа мандуулах ёслол зохион байгуулахдаа энэхүү протоколд дурдсан дүрмийг дагана хэмээн заажээ (Australian Government, 2025).
	– Викториа мужийн зохицуулалт (Department of Education, Victoria, 2025) Муж бүр өөрийн зохицуулалттай тул Викториа мужийг	Австралийн Викториа мужийн Боловсролын газраас сургуулиудын Төрийн далбааг мандуулах, ёслолын удирдамжийг баталсан. Тус удирдамжид сургуулиудын төрийн далбаа мандуулахтай холбоотой шаардлагуудыг тодорхойлохоос гадна Австрали улсын соёлын олон талт байдалтай холбоотой зохицуулалтуудыг тусгасан байна. (Department of Education, Victoria, 2025).

<sup>4</sup> АНУ. Виржиниа муж. Code of Virginia. Title 22.1. Education.

Хандах: <https://law.lis.virginia.gov/vacode/title22.1/chapter13/section22.1-202/>

<sup>5</sup> Франц. Education Code (2000). Хандах: [https://www.legifrance.gouv.fr/codes/article\\_lc/LEGIARTI000038847723](https://www.legifrance.gouv.fr/codes/article_lc/LEGIARTI000038847723)

<sup>6</sup> Австрали. Australian National Flags Act (1953). Хандах: <https://www.legislation.gov.au/C1954A00001/latest/text>

	жишээ болгон авсан болно.	
Итали	– Итали улсын төрийн далбаа болон Европын Холбооны далбааг хэрэглэх, мандуулах тухай ерөнхий зохицуулалт <sup>7</sup> -ын тухай хууль	Тус хуулийн 2 дугаар зүйлд Итали Улсын төрийн далбаа болон Европын холбооны далбааг мандуулах төрийн статус бүхий байгууллагуудыг тодорхойлж, далбаа байрлуулах байршлыг заасан байна. Тухайлбал, §2.1.е Итали Улс болон Европын Холбооны далбааг бүх сургууль, их сургуулийн төв байрны барилгын гадна байрлуулна.
	– Итали Улсын төрийн далбаа болон Европын Холбооны далбааг төрийн захиргаа, нийтийн байгууллагууд ашиглах журмын тухай <sup>8</sup>	Харин энэхүү төрийн далбааг хэрэглэх журмын 1.4 дэх заалтад дээрх хуулийн §2.1.е дэх заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд бүх шатны улсын сургууль болон их сургуулийн төв байранд Итали Улсын төрийн далбаа болон Европын Холбооны далбааг байршуулна хэмээн нарийвчлан зохицуулжээ.
ОХУ	– ОХУ-ын төрийн далбааны тухай хууль <sup>9</sup>	Төрийн далбааны тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Оросын Холбооны Улсын Төрийн далбааг өмчийн хэлбэрээс үл хамааран боловсролын байгууллагууд болон залуучуудын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулдаг төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын байранд байнга мандуулах буюу тэдгээрийн нутаг дэвсгэрт байнга байршуулна.” гэж заасан.
	– Боловсролын сайдын 2022 оны тушаал “Төрийн далбааг мандуулах, буулгах стандарт”	Төрийн далбааг мандуулах, буулгах, байрлуулах ёслолын үйл ажиллагааг зохицуулсан.

<sup>7</sup> Итали. Law №22. General provisions on the use of the flag of the Italian Republic and that of the European Union (1998). Хандах: <https://www.parlamento.it/parlam/leggi/980221.htm>

<sup>8</sup> Итали. Decree of The President of The Republic №121 Regulation governing the use of the flags of the Italian Republic and the European Union by state administrations and public bodies (2000). Хандах: [https://presidenza.governo.it/ufficio\\_cerimoniale/normativa/dpr\\_20000407\\_121\\_bandiere.pdf](https://presidenza.governo.it/ufficio_cerimoniale/normativa/dpr_20000407_121_bandiere.pdf)

<sup>9</sup> ОХУ. №1-ФКЗ “О Государственном флаге Российской Федерации” (2000 [2025]). Хандах: [https://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_29679/ebce2c95ce052d3c651180bf3cba630d365a714e/](https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_29679/ebce2c95ce052d3c651180bf3cba630d365a714e/)

Энэтхэг	<ul style="list-style-type: none"> <li>– Энэтхэгийн далбааны тухай хууль<sup>10</sup></li> </ul>	<p>Энэтхэгийн далбааны тухай хуулийн хоёрдугаар бүлэгт далбааг төрийн болон хувийн байгууллага мөн боловсролын байгууллагад хэрэглэх, байрлуулах, мандуулах зохицуулалт тусгагдсан байна.</p> <p>Тус хуулийн §2.1-т бүх төрийн болон хувийн байгууллага, боловсролын байгууллагууд тодорхой хориглох заалтуудаас бусад тохиолдолд хязгаарлалтгүйгээр Төрийн далбааг хэрэглэж болно. Мөн §2.2-т Төрийн далбааны нэр төр, хүндэтгэлийг чанд сахисан нөхцөлд баярын болон бусад бүх өдөр, тохиолдлуудад Төрийн далбааг мандуулах буюу байршуулж болно гэж тус тус зохицуулсан байна.</p>
Сингапур	<ul style="list-style-type: none"> <li>– Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль<sup>11</sup></li> <li>– Төрийн бэлгэ тэмдгийн тухай журам<sup>12</sup></li> <li>– Үндэсний боловсролын хөтөлбөр (Ministry of Education Singapore, 2022).</li> </ul>	<p>Тус улс нь төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль болон түүнийг дагалдан гарсан журамд төрийн далбааг мандуулах, байрлуулах дэгийн талаар зохицуулсан боловч мандуулах, байрлуулах газрыг тодорхой заагаагүй байна. Хэдийгээр төрийн далбааг сургуулийн орчинд хэрэглэх талаар тусгайлсан зохицуулалт байхгүй ч, 1997 оноос өнөөг хүртэл Үндэсний сургалтын хөтөлбөрийн хүрээнд өдөр бүр мандуулж хүндэтгэл үзүүлж хэвших талаар тусгагдаж, уламжлал болсон байна (Ministry of Education Singapore, 2022).</p>
Тайланд	<ul style="list-style-type: none"> <li>– Төрийн далбааг боловсролын байгууллагад мандуулах журам<sup>13</sup></li> </ul>	<p>Энэхүү журмыг Тайланд Улсын Засгийн газраас 1986 онд баталсан “Төрийн далбаа болон гадаад улсын далбааг хэрэглэх мандуулах” журамд нийцүүлэн 2004 онд Боловсролын сайд баталсан. Тус журмыг өмчийн хэлбэр үл хамааран бүх түвшний сургууль, сургалтын байгууллага дагаж мөрдөх бөгөөд далбаа мандуулах, буулгах өдөр, цагийг тодорхой зааж өгсөн байна.</p>
Филиппин	<ul style="list-style-type: none"> <li>– Төрийн далбаа, дуулал, уриа, сүлд болон бусад бэлгэ тэмдгийн тухай хууль<sup>14</sup> (№8491)</li> </ul>	<p>Энэ хууль нь төрийн далбааны дүрслэл, хэрэглээ, ёслолын журам, төрийн дуулал, тангараг болон бусад төрийн бэлгэ тэмдгийн хэрэглээг зохицуулсан байдаг.</p> <p>Тус хуулийн 5 дугаар зүйлд Төрийн далбааг боловсролын байгууллагууд жилийн турш өдөр бүр мандуулна гэж заасан байдаг.</p>
	<ul style="list-style-type: none"> <li>– Боловсролын бүх байгууллагад төрийн далбааны ёслолыг заавал</li> </ul>	<p>Тус хуулийн 1-р зүйл. Боловсролын бүх байгууллага өдөр бүр төрийн далбааны ёслолыг заавал зохион байгуулахаар тусгагдсан. Харин төрийн далбааны ёслолыг үйлдээгүй тохиолдолд тухайн боловсролын байгууллагын удирдлагад захиргааны хариуцлага хүлээлгэх зохицуулалттай байна.</p>

<sup>10</sup> Энэтхэг. Flag Code of India (2002). Хандах:

[https://www.wbja.nic.in/wbja\\_adm/files/Flag%20Code%20of%20India.pdf](https://www.wbja.nic.in/wbja_adm/files/Flag%20Code%20of%20India.pdf)

<sup>11</sup> Сингапур. National Symbols Act (2022). Хандах: <https://sso.agc.gov.sg/Act/NSA2022?ProvIds=P11-#P11->

<sup>12</sup> Сингапур. National Symbols Regulations (2023). Хандах: <https://sso.agc.gov.sg/SL/NSA2022-S536-2023?DocDate=20230731&WholeDoc=1>

<sup>13</sup> Тайланд. Rule of The Ministry of Education on The Flying of The National Flag in Educational Institutions

(2004,[2018]). Хандах: <https://ops.moe.go.th/wp-content/uploads/2018/05/3.R-of-M-on-the-Fly-Flag-2004-FINAL.pdf>

<sup>14</sup> Филиппин Улс. Republic Act №8491. An Act Prescribing The Code of The National Flag, Anthem, Motto, Coat-Of-Arms and Other Heraldic Items and Devices of The Philippines (1998). Хандах:

<https://www.officialgazette.gov.ph/1998/02/12/republic-act-no-8491/>

	хийх тухай хууль <sup>15</sup> (№1265)	
БНХАУ	– Төрийн далбааны тухай хууль <sup>16</sup>	Төрийн далбааны тухай хуулийн 6 дугаар зүйлд Төрийн далбааг ажлын өдрүүдээр мандуулах байршлыг тодорхойлсон байдаг. Тухайлбал, Сургуулиуд өвөл, зуны амралт болон амралтын өдрүүдээс бусад өдөр мандуулахаар тусгагдсан байна. Харин цэцэрлэгүүд боломжтой нөхцөлд сургуулиудад зориулан гаргасан журамд нийцүүлэн нээлттэй байх өдрүүдэд мандуулж болно гэж тусгажээ.

*Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар*

Судалгаанд хамрагдсан улс орнуудын жишээнээс харахад төрийн далбааг боловсролын байгууллагад байрлуулах, мандуулах асуудлыг ихэнх улс хууль, журам болон албан ёсны удирдамжаар нарийвчлан зохицуулсан байна. Зарим улс (АНУ зэрэг) төрийн далбаатай холбоотой зохицуулалтыг холбооны түвшинд заавал биелүүлэх шинжгүй, зөвлөмжийн хэлбэрээр тусгасан бол БНХАУ, Филиппин, ОХУ зэрэг улсад сургуулиудад төрийн далбааг байнга мандуулах, ёслол үйлдэхийг хуульчилж, заавал дагаж мөрдөх зохицуулалттай байна. Мөн Франц, Итали зэрэг оронд төрийн далбааг сургуулийн орчинд байрлуулахыг хуульд шууд заасан нь эх оронч үзэл, иргэний ухамсрыг төлөвшүүлэх бодлоготой нягт уялдаж байна. Харин Сингапурын хувьд тусгайлсан хатуу хуульчилсан шаардлагаас илүүтэйгээр үндэсний боловсролын хөтөлбөрийн хүрээнд уламжлал болгон хэрэгжүүлж ирсэн нь онцлог байна. Иймд олон улсын туршлагаас харахад төрийн далбааг сургуулийн орчинд хэрэглэх асуудал нь тухайн улсын түүх, соёл, төрийн бодлогын онцлогт нийцсэн байдлаар өөр өөр хэлбэрээр зохицуулагдаж байна.

---oOo---

Дэлхийн олон улс оронд сургуулийн орчинд төрийн бэлгэдлийг ашиглах нь эх оронч үзэл, иргэний үнэт зүйлсийг төлөвшүүлэх бодлогын нэг хэсэг болсоор ирсэн. Гэвч энэ асуудал нь зөвхөн хүмүүжлийн ач холбогдлоороо бус, ардчилал, хүний эрх, үзэл бодлын эрх чөлөөтэй хэрхэн нийцэх вэ гэсэн маргааныг дагуулдаг байна. Улс орнууд түүх, улс төрийн нөхцөл байдал, нийгмийн үнэт зүйлсээсээ хамааран төрийн далбаа, дууллыг боловсролын орчинд хэрэглэхдээ харилцан адилгүй байр суурь баримталж байгаа талаар өмнө нь дурдсан билээ. Энэ талаар зарим улсуудын жишээг хоёрдогч эх үүсвэрээс авч доор харуулав.

Франц, Япон, АНУ-ын жишээг авч үзэн, сургуулийн орчин дахь төрийн бэлгэдлийн талаарх бодлого, түүнийг тойрсон маргаан, шүүмжлэлийг харьцуулан авч үзнэ.

### **Шигтгээ**

#### **Франц Улс**

Франц улс 2019 онд Боловсролын тухай хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулж, бүх бага, дунд сургуулийн анги танхимд Францын төрийн далбаа болон Европын Холбооны далбааг заавал байрлуулах шинэ зохицуулалт хийсэн (Euronews, 2019). Францын эрх баригчид уг арга хэмжээг эх оронч хүмүүжил, иргэний үнэт зүйлсийг бэхжүүлэх алхам хэмээн тайлбарласан. Тодруулбал, сургуулийн орчинд улсын далбааг байрлуулах нь

<sup>15</sup> Филиппин Улс. Republic Act №1265. An Act Making Flag Ceremony Compulsory in All Educational Institutions (1955). Хандах: [https://lawphil.net/statutes/repacts/ra1955/ra\\_1265\\_1955.html](https://lawphil.net/statutes/repacts/ra1955/ra_1265_1955.html)

<sup>16</sup> БНХАУ. National Flag Law of the PRC (1990 [2020]). Хандах: <https://www.chinalawtranslate.com/en/flaglaw2020/>

сурагчдын үндэсний үнэмлэхүй мэдрэмжийг дээшлүүлэх нэг арга гэж үзжээ. Мөн ЕХ-ны далбаа нь Францыг Европын Холбооны салшгүй хэсэг болохыг сануулж, олон улсын иргэнлэг үзэл төлөвшүүлэхэд нэмэртэй хэмээн дурдсан байдаг (Euronews, 2019). Гэвч энэ санаачилга гарсны дараа Францын зарим багш, сэхээтнүүд “сургууль нь цэргийн хуаран биш” гэж шүүмжилж, улсын далбааг анги бүрд өлгөх нь хэт үндсэрхэх хандлагыг өгч магадгүй хэмээн болгоомжилж байсан (мөн тэнд).

### **Япон Улс**

Япон Улсын Асахи Шимбун сонинд 2004 онд “Ёслолын үйл ажиллагааг сурагчдад нь буцааж өг” хэмээх гарчиг бүхий нийтлэл хэвлэгджээ. Гол агуулга нь: “Токиогийн боловсролын зөвлөл төгсөлтийн ёслолын үеэр төрийн дуулал дуулж, далбааны өмнө зогсоогүй багш нарт сахилгын шийтгэл ногдуулсан нь Японд урьд өмнө байгаагүй хатуу арга хэмжээ байсан. Зөвлөлийн хэрэглэж буй энэхүү арга барил нь залуу үеийнхний сэтгэл зүрхэнд төрийн далбаа, төрийн дууллыг хайрлах чин сэтгэлийн хайр хүндэтгэлийг төлөвшүүлж чадна гэдэгт бид итгэхгүй байна хэмээн шүүмжилжээ (Asia-Pacific Journal , 2004).

### **АНУ**

Баруун Виржиниа мужийн шүүхээс 1943 онд сурагчийг тангараг өргөх ёслолд оролцохыг үүрэг болгосон нь Үндсэн хуулийн үг хэлэх эрх чөлөөний зарчмуудыг зөрчиж байна гэж үзсэн (Congressional Research Service, 2019).

## **2.2. Төрийн далбааг сургуулийн орчинд хэрэглэх давтамж, хугацаа**

Судалгаанд авагдсан улсуудын сургуулийн орчин дахь төрийн далбааны хэрэглээг харьцуулан үзэхэд Азийн улс орнууд ихэвчлэн өдөр бүр мандуулах, ингэхдээ долоо хоногт нэг удаа ёслол төгөлдөр мандуулах зохицуулалттай байна. Европт Азийн орнууд шиг өдөр бүр тангараг өргүүлэх практик нийтлэг биш ч, сургуулийн байр, анги танхимд төрийн далбааг байрлуулах хандлага түгээмэл байна. Харин АНУ-д сургуулийн орчин дахь төрийн далбааны хэрэглээний тогтсон уламжлалаараа онцлог юм. Хэдийгээр холбооны түвшинд хуулиар төрийн далбааг заавал мандуулах, ёслол хийх зэрэг байдлаар хатуу тогтоогоогүй ч, ихэнх муж улсуудын хуулийн дагуу сургуулиудад анги бүрд төрийн далбааг байрлуулах, өдөр бүр хичээл эхлэхийн өмнө сурагчдыг төрийн далбаанд тангараг өргүүлэх (Pledge of Allegiance) ажиллагаа явуулдаг байна. Харин Австрали Улсын хувьд сургуулийн орчин дахь төрийн далбааны хэрэглээ нь эх оронч үзэл, иргэний бахархал төлөвшүүлэхийн зэрэгцээ олон соёлт нийгмийн иргэн гэсэн ойлголтыг суулгахад чиглэдгээрээ онцлогтой байна.

**АНУ-ын Виржиниа муж:** Виржиниа мужийн хуулийн<sup>17</sup> §22.1-202(C) Сургуулийн анги танхим бүрд **өдөр бүр** төрийн далбаанд үнэнч байхаа тангараглах (Pledge of Allegiance) ёслол үйлдэх ёстой бөгөөд сургуулийн зөвлөл нь хичээлийн өдрийн аль тохиромжтой цагт тангараг өргөх ёслолыг зохион байгуулахыг тогтооно. Мөн анги танхим бүрд төрийн далбааг байршуулсан байхыг Виржиниа мужийн хуулиар зохицуулсан байдаг. Түүнчлэн хэрэв сурагч өөрөө, түүний эцэг эх эсвэл хууль ёсны асран хамгаалагч нь шашны болон бусад үндэслэлээр уг ёслолд оролцохоос татгалзвал, сурагчийг тангараг уншихыг албадахгүй хэмээн заасан байна.

<sup>17</sup> АНУ. Виржиниа муж. Code of Virginia. Title 22.1. Education. Хандах: <https://law.lis.virginia.gov/vacode/title22.1/chapter13/section22.1-202/>

**Австрали Улсын Викториа муж:** Сургууль нь Австралийн үндэсний далбааг сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаанд мандуулах болон ашиглах боломжтой. Ингэхдээ сурагчдыг далбаа мандуулах ёслолд албадан оролцуулахгүй байх, тэд соёл, шашин, итгэл үнэмшил дээр үндэслэн татгалзаж болох зохицуулалттай (Department of Education, Victoria, 2025). Жишээлбэл, Викториа мужийн сургуулиуд Австралийн төрийн далбааг дараах байдлаар мандуулж болно. Үүнд, сурагчдад одоогийн далбаа, түүний түүх, ирээдүйн талаар эргэцүүлэн бодох боломжийг олгохын тулд тусгай тохиолдлоос бусад тохиолдолд хичээлийн өдөр бүрийн эхэнд өглөөний 8:00 цагаас ажлын цаг дуусах хүртэл далбааг мандуулдаг байна (State Government of Victoria, 2025).

**Франц Улс:** Сургуулиуд төрийн далбааг тусгайлан өдөр бүр өргөх шаардлагагүй, харин төрийн далбааны байнга нүдэнд харагдах байдлыг хангаж, сурагчид өдөр тутам ангидаа харж байх нөхцөлийг бүрдүүлсэн (Euronews, 2019).

**Итали Улс:** Төрийн далбаа болон Европын Холбооны далбааг төрийн захиргаа, нийтийн байгууллагууд ашиглах журмын §4.3-т хичээлийн болон шалгалтын өдрүүдэд төрийн далбааг ерөнхий боловсролын болон их сургуулиудын урд нар мандахад өргөж, нар жаргах үед буулгана гэж заасан.

**ОХУ:** Боловсролын яамны 2022 оны “Төрийн далбааг хэрэглэх тухай” №СК-296/06 дугаар албан тайлбар (Письмо Минобрнауки России)-т дурдсанаар **Долоо хоног бүрийн даваа гарагт төрийн далбааг мандуулна**. Мөн тус албан бичигт “Боловсролын байгууллага болон хүүхдийн амралт, сувилал, халамжийн газруудад төрийн бэлгэ тэмдгийг ашиглах нь оюун санаа, ёс суртахууны үнэт зүйлсийг төлөвшүүлэх, Оросын нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн хүн, гэр бүл, нийгэм, төр засгийн эрх ашгийн төлөөх биеэ авч явах дүрэм, хэм хэмжээг хэвшүүлэх хүмүүжлийн нэн тэргүүний зорилтуудтай нийцэж байх ёстой. Мөн суралцагчдад эх оронч үзэл, иргэний ухамсар, эх орноо хамгаалагчдын дурсгал болон эх орны баатруудын гавьяаг хүндэтгэх сэтгэлгээг төлөвшүүлэх, хууль ёс, хэв журмыг дээдлэх үзлийг суулгахад чиглэгдэх ёстой” хэмээн дурджээ (Министерство Просвещения Российской Федерации, 2022).

**БНХАУ:** Төрийн далбааны тухай хуулийн<sup>18</sup> 14 дүгээр зүйлд зааснаар төрийн далбааг мандуулах ёслолын үеэр төрийн дууллыг эгшиглүүлэх болон дуулах ёстой. Төрийн далбааг мандуулах үеэр оролцогчид төрийн далбааг харж зогсож, дүрэм журмын дагуу анхаарал хандуулах буюу хүндэтгэл үзүүлнэ. Мөн энэ үед төрийн далбааг гутаах үйлдэл хийхийг хориглоно. Амралтын үеэс бусад тохиолдолд далбаа мандуулах ёслолыг долоо хоногт нэг удаа зохион байгуулахаар хуульд заасан байна.

**Энэтхэг Улс:** Энэтхэгийн далбааны тухай хуульд<sup>19</sup> тодорхой тэмдэглэлт өдрүүдэд бүх сургууль далбаа мандуулж, ёслол хийхийг үүрэг болгодог. Бусад өдрүүдэд далбаа мандуулах нь албан журмын биш ч, сургуулиудад уламжлал болон тогтсон байдаг.

**Филиппин Улс:** Төрийн далбаа, дуулал, уриа, сүлд болон бусад бэлгэ тэмдгийн тухай хуулийн<sup>20</sup> (№8491) §18-д “Төрийн бүх байгууллага, боловсролын байгууллагууд Даваа гараг бүрийн өглөө төрийн далбаа мандуулах ёслол, Баасан гараг бүрийн орой төрийн далбаа буулгах ёслолыг тус тус үйлдэнэ. Ёслолын үйл ажиллагаа нь энгийн, хүндэтгэлтэй байх бөгөөд Филиппин улсын төрийн дууллыг эгшиглүүлнэ.”, §19-д

---

<sup>18</sup> БНХАУ. National Flag Law of the PRC (1990 [2020]). Хандах: <https://www.chinalawtranslate.com/en/flaglaw2020/>

<sup>19</sup> Энэтхэг. Flag Code of India (2002). Хандах:

[https://www.wbja.nic.in/wbja\\_adm/files/Flag%20Code%20of%20India.pdf](https://www.wbja.nic.in/wbja_adm/files/Flag%20Code%20of%20India.pdf)

<sup>20</sup> Филиппин Улс. Republic Act №8491. An Act Prescribing The Code of The National Flag, Anthem, Motto, Coat-Of-Arms and Other Heraldic Items and Devices of The Philippines. Хандах:

<https://www.officialgazette.gov.ph/1998/02/12/republic-act-no-8491/>

“Ерөнхийлөгчийн ажлын алба Үндэсний түүхийн хүрээлэнгээс гаргасан зөвлөмжийн дагуу далбааны ёслолыг зохих ёсоор явуулах дүрэм журмыг гаргана.” гэж тус тус заасан.

**Сингапур Улс:** Шинэ хууль, журам нь Төрийн бэлгэ тэмдгийг зохистой ашиглах эрх зүйн хүрээг бий болгохын зэрэгцээ, Сингапурчууд үндэсний бахархал, эв нэгдлээ илэрхийлэх зорилгоор илүү өргөн хүрээнд ашиглах боломжийг олгохыг зорьсон байна (Baker McKenzie, 2023). Харин Үндэсний боловсролын хөтөлбөрийг өмнө дурдсанчлан 1996 онд Боловсролын яамнаас санаачлан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд зорилго нь сурагчид болон залуу сингапурчуудын дунд үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, үндэсний онцлог, үнэт зүйлийн талаарх ухамсрыг төлөвшүүлэхэд оршино (NLB, 2014). Тус хөтөлбөр нь Иргэний ёс зүйн боловсролын нэг хэсэг болон боловсролын хөтөлбөрт тусгагдсан байдаг. Мөн тус хөтөлбөрийн хүрээнд сурагчид өдөр бүр төрийн далбааг мандуулж, төрийн дуулал дуулдаг (Ministry of Education, Singapore, 2017).

**Тайланд Улс.** Төрийн далбааг боловсролын байгууллагад мандуулах журмын<sup>21</sup> 5 дугаар зүйл. Үндэсний далбааг дараах цагт мандуулж, буулгана:

(1) хичээлийн өдөр - сургууль эхлэх үед мандуулж, 18.00 цагт буулгана;

(2) хичээлгүй өдөр - 08.00 цагт мандуулж, 18.00 цагт буулгана.

Түүнчлэн төрийн далбааг мандуулах, буулгах болон далбаанд хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг Тайланд Улсад Төрийн болон Гадаадын далбааг ашиглах, мандуулах, байрлуулах тухай Ерөнхий сайдын Тамгын газрын дүрэм, В.Е. 2529 (1986)-тэй нийцүүлэн тухайн боловсролын байгууллагаас тогтоосон дүрэм, журмын дагуу зохион байгуулдаг.

---

<sup>21</sup> Тайланд. Rule of The Ministry of Education on The Flying of The National Flag in Educational Institutions (2004).  
Хандах: <https://ops.moe.go.th/wp-content/uploads/2018/05/3.R-of-M-on-the-Fly-Flag-2004-FINAL.pdf>



## ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд хамрагдсан улс орнуудын зохицуулалт, туршлагаас харахад төрийн далбааг сургуулийн орчинд хэрэглэх асуудал нь тухайн улсын түүхэн уламжлал, иргэний үнэт зүйл, боловсролын бодлогын зорилготой нягт уялдсан байдлаар зохицуулагдаж ирсэн байна. Улс орнуудын туршлагыг ерөнхийд нь дараах гурван үндсэн загварт ангилж болохоор байна. Үүнд:

1.Хуульчлан тогтоосон, заавал мөрдөх загвар: БНХАУ, Филиппин, ОХУ, Тайланд зэрэг улсад төрийн далбааг боловсролын байгууллагад байнга мандуулах, тодорхой давтамжтайгаар ёслол зохион байгуулахыг хууль, журам, сайдын тушаалаар заавал хэрэгжүүлэх хэм хэмжээ байдлаар зохицуулсан байна. Энэ загвар нь эх оронч үзэл, иргэний ухамсрыг системтэй төлөвшүүлэх давуу талтай боловч сурагч, багш нарын үзэл бодол, эрх чөлөөтэй зөрчилдөх эрсдэл харьцангуй өндөр байдаг.

2.Хуульд суурилсан боловч албадлага багатай загвар: Франц, Итали зэрэг Европын орнуудад төрийн далбааг сургуулийн хичээлийн байр, анги танхимд байршуулахыг хуульчилсан ч өдөр тутмын ёслол, тангараг өргүүлэхийг албадсан зохицуулалт харьцангуй бага байна. Энэ нь төрийн бэлгэ тэмдгийн харагдах байдлыг илэрхийлэх замаар иргэний ухамсрыг төлөвшүүлэхийг зорьж байгаа бөгөөд хүний эрх, үзэл бодлын эрх чөлөөтэй зөрчилдөх эрсдэлийг харьцангуй багасгасан онцлогтой.

3.Боловсролын хөтөлбөрт суурилсан, сайн дурын загвар: АНУ, Австрали, Сингапур зэрэг улсад төрийн далбааг хэрэглэх асуудлыг шууд албадсан хуульчилсан хэлбэрээс илүүтэйгээр боловсролын хөтөлбөр, сургуулийн дотоод журам, уламжлалд тулгуурлан хэрэгжүүлж байна. Энэ загвар нь сурагчдын оролцоог сайн дурын үндсэн дээр хангаж, иргэний үнэт зүйлийг ухамсар, хандлагаар төлөвшүүлэхэд чиглэдэг давуу талтай.

Монгол Улсын хувьд төрийн далбааны эрх зүйн байдал нь Үндсэн хууль болон Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулиар зохицуулагдаж, иргэд, байгууллагад төрийн бэлгэ тэмдгийг дээдлэн хүндэтгэж хэрэглэх өргөн хүрээний эрх чөлөөг олгосон байна. Гэвч бүх шатны сургуульд төрийн далбааг хэрхэн, ямар хэлбэрээр, ямар давтамжтай хэрэглэх талаар тусгайлсан, салбарын нарийвчилсан зохицуулалт одоогоор байхгүй байна.

Иймд олон улсын туршлагаас дүгнэхэд Монгол Улсад төрийн далбааг сургуулийн орчинд хэрэглэх асуудлыг шууд албадсан, хатуу зохицуулалтаар бус, харин боловсролын бодлогын зорилго, хүний эрх, үзэл бодлын эрх чөлөөг харгалзан үзсэн, үе шаттай, уян хатан байдлаар зохицуулах нь илүү оновчтой гэж үзэж байна. Тухайлбал, төрийн далбааг иргэний боловсрол, эх оронч хүмүүжлийн агуулгатай уялдуулан сургалтын хөтөлбөрт тусгах, сургуулийн орчинд зохистой байдлаар байрлуулах, ёслолын үйл ажиллагаанд сурагчдыг албадан бус, сайн дураар оролцуулах зарчмыг баримтлах нь бодлогын хувьд илүү тохиромжтой хувилбар байж болно.

## НОМ ЗҮЙ

- Australian Government. (2025). *Australian National Flag protocols*. <https://www.pmc.gov.au/honours-and-symbols/australian-national-symbols/australian-national-flag/australian-national-flag-protocols>
- Риа Новости. (2024). *СФ одобрил закон о государственном флаге на образовательных учреждениях*. <https://ria.ru/20240320/flag-1934412494.html>
- Министерство Просвещения Российской Федерации. (2022). *Письмо от 15 апреля 2022 г. N СК-295/06 Об использовании государственных символов Российской Федерации*. [https://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_417345/4c67235dfad7c2fb10b59e7ea7f26dde2afe4f3e/](https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_417345/4c67235dfad7c2fb10b59e7ea7f26dde2afe4f3e/)
- NLB. (2014). *Launch of National Education*. <https://www.nlb.gov.sg/main/article-detail?cmsuuiid=44fa0306-ddfe-41bc-8bde-8778ff198640>
- Asia-Pacific Journal . (2004). *The Flag and the Anthem: Enforcing Japanese Patriotism*. <https://apjif.org/shimbun-asahi/2024/article>
- Euronews. (2019). *French and EU flags compulsory in classrooms as France goes back to school*. <https://www.euronews.com/2019/09/02/french-and-eu-flags-compulsory-in-classrooms-as-france-goes-back-to-school>
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (2025). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. <https://legalinfo.mn/mn>
- State Government of Victoria. (2025). *Flags and Patriotic Ceremonies* : <https://www2.education.vic.gov.au/pal/flag-flying-and-patriotic-ceremonies/guidance/flying-flags>
- Congressional Research Service. (2019). *Frequently Asked Questions About Flag Law*. [https://www.congress.gov/crs\\_external\\_products/R/PDF/R45945/R45945.2.pdf](https://www.congress.gov/crs_external_products/R/PDF/R45945/R45945.2.pdf)
- Ministry of Education, Singapore. (2017). *NATIONAL EDUCATION REVIEW 2016-2017*: <https://www.moe.gov.sg/-/media/files/programmes/ne-review-collateral.pdf>
- Department of Education, Victoria. (2025). *Flags and Patriotic Ceremonies*. <https://www2.education.vic.gov.au/pal/flag-flying-and-patriotic-ceremonies/policy>
- Ministry of Education Singapore. (2022). *National Education*. <https://www.moe.gov.sg/-/media/files/programmes/ne-review-collateral.pdf>
- Queen's University Belfast. (2017). *What Do National Flags Stand for? An Exploration of Associations Across 11 Countries*. <https://doi.org/10.1177/0022022116687851>
- Baker McKenzie. (2023). *Singapore: Rules governing usage of Singapore flag eased with the National Symbols Act and National Symbols Regulations 2023*. <https://www.lexology.com/library/detail.aspx?g=a1d3150e-a4f2-4414-84a7-d9f41273417a>